

26.

АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙНХУРАЛДААНЫ
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2019.10.25

№ 20

Алтай хот

№	Хэлэлцэх асуудал	Хэн хэлэлцүүлэх	Хэн байлцах	Гарах шийдвэр
1.	Ажлын албаны бүтэц орон тоо баилах тухай	А.Амарзаяа	О.Аюурзана	Тогтоол 85
2.	"Алтай орон сууцны корпораци" ААТҮГ-ын захирлыг томилохоор зөвшилцөх тухай	В.Сүррагчаа	Д.Баттайван	Тэмдэглэл
3.	Төрийн дээд шагналд өргөн мэдүүлэх тухай	Д.Отгонбаяр	Б.Итэшмаа	Тогтоол 86

ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
АЖЛЫН АЛБА



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 85

Есөнбулаг сум

Ажлын албаны бүтэц, орон
тоо батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны бүтэц, орон тоог 13 байхаар тогтоож, хавсралтаар баталсугай.

2. Ажлын албаны ажилтнуудын ажил үүргийн хуваарь, албан тушаалын тодорхойлолтыг нарийвчлан боловсруулж, холбогдох байгууллагаар баталгаажуулан, мөрдөж ажиллахыг нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Амарзаяа)-д даалгасугай.

3. Уг тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 72 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА  БАТЖАРГАЛ



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 26

Есөнбулаг сум

Төрийн дээд шагналд өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрхэлсэн ажилдаа олон жил үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрийн өндөр амжилт гарган, аймаг орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулсан бодит хувь нэмрийг өндрөөр үнэлж, хавсралтад дурдсан хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

3. Төрийн дээд шагналд тодорхойлогдсон хүмүүсийн тодорхойлолт, материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын алба, нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Амарзаяа)-д даалгасугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ

